

Бандунгийн бага хурал ба БНМАУ Ази, Африкийн орнуудтай харилцах цонх нээсэн нь (1955-1961)

Цэдэндамбын Батбаяр

*ШУА-ийн Түүх, угсаатан судлалын хүрээлэн
Доктор (Sc.D), Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайд асан
Цахим хаяг: tsedendamba.bud@gmail.com*

Хураангуй: Дэлхийн II дайны дараа колончлолоос чөлөөлөгдөж биеэ даасан улс байгуулсан Ази, Африкийн орнууд олон улсын харилцааны шинэ хүчин зүйл болсон билээ. Тэдгээр улс орнуудын дийлэнх нь бусад улс оронтой энх тайвнаар зэрэгцэн орших үндсэн дээр харилцахыг эрмэлзэж байлаа. Энэ эрмэлзэл нь 1954 онд БНХАУ, БНЭУ-ын хоорондын харилцаанд тунхагласан Панча-Шила хэмээх таван зарчимд тусгалаа олов. Энэхүү таван зарчим нь нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал ба суверенитетийг хүндэтгэх, харилцан үл довтлолцох, эрх тэгш харилцан ашигтай байх, энх тайвнаар зэрэгцэн орших зэрэг болно. 1955 оны 4 дүгээр сард Индонезийн Бандунг хотод хуралдсан Ази, Африкийн 29 орны Бага хурал олон улсын харилцааны түүхэнд онцгой байр суурийг эзэлдэг. Дэлхийн хүн амын талаас илүү нь оршин суудаг Ази, Африк хоёр тивийн Төр засгийн тэргүүн, Гадаад хэргийн сайд нар анх удаа хуран цугларч, дэлхийн улс төрд хоёр тивийн орнуудын гүйцэтгэх үүрэг, шинэ колоничлолын эсрэг, эдийн засаг, соёлын хамтын ажиллагааг бэхжүүлэх, хүний эрх ба өөрөө засан тохинох эрхийг хэрэгжүүлэх, улс хоорондын харилцаанд баримтлах Бандунгийн 10 зарчим зэргийг хэлэлцэн тохирч чадсан нь дэлхийн геополитикт тун содон сонин үйл явдал болсон билээ. Панча-Шила ба Бандунгийн 10 зарчмыг дэлхийн олон улс орон, түүн дотор БНМАУ ч талархалтай хүлээн авсан юм.

Түлхүүр үгс: Бандунгийн бага хурал, Ази, Африкийн орнууд, энх тайвнаар зэрэгцэн орших 5 зарчим, 10 зарчим, БНМАУ-ын энх тайванч бодлого.

Нэг. Бандунгийн бага хурлын тухай

1. БНМАУ 1950-иад оны дэлхий дахин, бүс нутгийн энх тайвны төлөө тэмцэлд

1949 оноос эхлэн БНМАУ социалист бусад орны хамт дэлхийн энх тайвны талынхны олон улсын их хурал хуралдуулах тэмцэлд нэгдсэн байна. 1949 онд Парис, Прагад болсон энх тайвны талынхны анхдугаар их хуралд Ю.Цэдэнбал тэргүүтэй БНМАУ-ын олон нийтийн төлөөлөгчид оролцож, энх тайвны төлөө социалист орнуудын үйл ажиллагаанд дуу хоолойгоо нэмэрлэжээ. Энэхүү хөдөлгөөн цаашдаа өргөжих нь тодорхой байсан тул Үндэсний хороо байгуулах шаардлага үүсчээ. 1949 оны 9 дүгээр сарын 21-22-нд Улаанбаатарт монголын энх тайвны талынхны анхдугаар бага хурал болж Ю.Цэдэнбал “Шинэ дайн өдөөгчдийг эсэргүүцэн, улс түмний өнө урт бат найрамдлын төлөө” гэсэн илтгэл тавьж, Монголын энх тайвны найрамдлын байгууллагын эх үүсвэрийг тавьжээ. Тус бага хурлаас Монголын энх тайвныг хамгаалах Үндэсний хороог байгуулж, 21 хүний бүрэлдэхүүнтэй тэргүүлэгчид, Хорооны даргаар Б.Ширэндэвийг сонгосон байна.¹

Энх тайвны талынхны Монголын их хурал 1950 оны 10 дугаар сарын 11-нд нээгдэж, “Монголын ард түмэн шинэ дайн өдөөгчдийн эсрэг, энх тайвны төлөө тэмцэлд” гэсэн илтгэлийг Б.Ширэндэв тавьж, тус их хурлаас Варшавт болох дэлхий дахины II их хуралд очих төлөөлөгчөөр

Б.Ширэндэв, С.Удвал нарын 10 хүнийг сонгов. Варшавт 1950 оны 11 дүгээр сард болсон энх тайвны талынхны дэлхий дахины II их хуралд Б.Ширэндэв тэргүүтэй Монголын олон нийтийн төлөөлөгчид оролцож, үг хэлснээс гадна дэлхий дахины ард түмэнд хандан гаргасан тунхагт нэгджээ. МЭТХ Үндэсний хороо 1950-иад онд дэгдсэн Солонгосын дайны үеэр Солонгосын ард түмэнд туслах бүх ард түмний хөдөлгөөнийг өрнүүлэх, Солонгос, Вьетнам дахь дайн, Суэцийн сувгийн район дахь будлианыг зогсоохын төлөө тэмцэлд дуу хоолойгоо нийлүүлж байлаа. БНМАУ-ын насанд хүрсэн бүх хүмүүс буюу 600 мянга гаруй иргэд Стокгольмын уриа ба таван их гүрний хооронд энх тайвны гэрээ байгуулах тухай урианд гарын үсгээ зурах ажлыг зохион байгуулав. Социалист орнуудын энх тайвны төлөө бодлогод нийцүүлэн БНМАУ-ын Бага хурлын Тэргүүлэгчид 1951 оны 2 дугаар сарын 27-нд “Энх тайвныг хамгаалах хууль” баталсан байна. Тус хууль дайны тухай суртал нэвтрүүлэх буюу түүнд дэмжлэг үзүүлсэн этгээдийг гэмт хэрэгтэн гэж үзэж, 10-25 жилээр хорих ял оноох зэргээр шийтгэж байхыг хуульчилжээ.²

1950-иад оны эхээр манай өмнөд хөрш БНХАУ дэлхийн тавцан дээр байр сууриа бэхжүүлэхийн тулд Ази, Номхон далайн орнуудтай харилцаагаа сайжруулахыг чухалчилж байв. Дээрх орнуудын олон нийтийн хүч, нийгмийн нэрт зүтгэлтнүүдийг өөртөө татах зорилгоор 1952 оны 10 дугаар сард Бээжин хотноо Ази,

1 Б.Ширэндэв. Далайн давалгаанаар /Туужчилсан роман/. УБ., 1993. 206-207-р тал.

2 Монгол Улсын түүх, УБ., 2003. 5-р боть, 258-259-р тал

Номхон далайн орнуудын энх тайвны бага хурлыг зохион байгуулжээ. 9 дүгээр сарын сүүлээр болсон Бэлтгэл ажлын хорооны хуралдаанд бэлтгэл ажлын хорооны гишүүд түүн дотор БНМАУ-аас Б.Ширэндэв оролцжээ. Ази, Номхон далайн орнуудын бага хурал 1952 оны 10 дугаар сарын 3-нд Бээжин хотноо нээлтээ хийж, нийт 53 орны төлөөлөгчид, Энх тайвны дэлхий дахины Зөвлөлийнхөн оролцсон бөгөөд БНМАУ-аас Б.Ширэндэв, М.Дүгэрсүрэн, зохиолч Ч.Лодойдамба, эмч Дуламжав нарын хүмүүс оролцжээ.³

1957 онд Ази-Африкийн эв санааны нэгдлийн Монголын Хороог Б.Ширэндэв, Ш.Лувсанвандан, Б.Ринчэн, Л.Цогзолмаа, Ү.Ядамсүрэн нарын 13 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, даргаар нь Б.Ширэндэвийг сонгосон байна. МАХН, Засгийн газраас Бандунгийн 1955 оны бага хурлын дараа Ази-Африкийн орнуудтай эв санааны нэгдлээ бэхжүүлэхэд онцгой анхаарал хандуулж, Ази-Африкийн орнуудын эв санааны нэгдлийн бага хурлын бэлтгэл хорооны Кайрт 1957 оны 10 дугаар сард болсон хуралд, дараа нь Кайрт мөн оны 12 дугаар сард болсон бага хуралд Б.Ширэндэв нарын төлөөлөгчдийг оролцуулсан байна. Манай төлөөлөгчид Кайр хотод болсон бэлтгэл хорооны хурал, бага хурал дээр хэлсэн үг, бусад орны төлөөлөгчидтэй уулзаж ярилцахдаа Египет улсын эсрэг Англи, Францын зэвсэгт хүчин болон Израилаас эзэрхэн довтолсныг эрс

буруушааж, Ази, Африкийн орнуудын тусгаар тогтнолыг дэмжиж, Монголын ард түмэн дээрх хоёр тивийн ард түмэнтэй эв санааны нэгдэлтэй байдгийг илэрхийлж байв.⁴

2. 1955 оны Бандунгийн бага хурал

Дэлхийн II дайны дараа Их Британи Энэтхэг, Цейлон, Бирм, Ойрхи Дорнод дахь колонийн эзэмшлээ алдав. Энэтхэг 1947 оны 8 дугаар сарын 15-нд тусгаар тогтносон боловч Британийн хамтын нөхөрлөлийн хүрээнд Энэтхэг, Пакистан хоёр улс болж салав. 1948 оны 1 дүгээр сарын 4-нд Бирм, дараахан нь Цейлон тусгаар тогтнолоо олж авав. Ойрхи Дорнодод шинээр хэдэн улс газрын зураг дээр бий болсон нь Францын хяналтад байсан Сири, Ливан, Их Британий мэдэлд байсан Трансиордан байлаа. Тэдний араас 1952 онд Египет, 1956 онд Судан, Марокко, Тунис эрх чөлөөгөө олж авав. Ази, Африкийн шинэ тулгар орнуудын өмнө нийгмийн байгууллаа сонгох, гадаад бодлогоо тодорхойлох, олон улсын тавцанд гарах гэх мэт олон сорилт, асуудлууд тулгарч байлаа.⁵

Анх 1954 оны 4-5 дугаар сард Коломбод болсон Энэтхэг, Бирм, Индонез, Пакистан, Цейлоны Ерөнхий сайд нарын зөвлөгөөнөөс Бандунгийн бага хурлыг зарлан хуралдуулах санаачлагыг гаргажээ. 1954 оны 12 дугаар сард Индонезийн Богор хотод “Коломбогийн 5 орон”-ы хоёрдахь зөвлөгөөн болж, Ази, Африкийн шинээр тусгаар тогтнолоо олсон

3 Б. Ширэндэв. Түүвэр зохиол. 8-р боть. 187-188-р тал.

4 Мөн тэнд. 191-192-р тал.

5 Д.Баярхүү. Олон улсын харилцаа XX зуунд. УБ., 1994.110-111-р тал.

орнуудын Бага хурлыг Индонезийн Бандунгт хийх Индонезийн санаачлагыг дэмжсэн байна.⁶

Ази, Африкийн орнуудын бага хурал 1955 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр Индонезийн Бандунг хотод нээгдэж, Ази, Африкийн 29 орны 340 орчим төлөөлөгч оролцжээ. Бага хуралд санаачлагч Энэтхэг, Бирм, Индонез, Пакистан, Цейлон гэсэн 5 орноос гадна Афганистан, БНАВУ, Египет, Алтан эрэг /Гана/, Иордан, Ирак, Иран, Йемен, Камбож, БНХАУ, Лаос, Либери, Ливан, Ливи, Непал, Саудын Араб, Сири, Судан, Тайланд, Турк, Филиппин, Эфиоп, Өмнөд Вьетнам, Япон зэрэг 24 орон оролцсон байна. Бүгд Найрамдах Индонези Улсын Ерөнхийлөгч А.Сукарно бага хурлыг нээж, “өнгөт арьстан ард түмний оршин суудаг хоёр тивийн бага хурал хүн төрөлхтөний түүхэнд анх удаа нээгдсэний түүхт ач холбогдлыг” онцлон тэмдэглэв. Бага хурлын даргаар Индонезийн Ерөнхий сайд Састраамиджойог бүх төлөөлөгчид санал нэгтэй сонгожээ.

Түүнчлэн Ази, Африкийн орнуудын бага хурлын анхны бүгд хуралдаанаар хурлын журам ба хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг баталжээ. Хэлэлцэх асуудалд 1/ Эдийн засгийн хамтын ажиллагаа /Economic cooperation/, 2/ Соёлын хамтын ажиллагаа /Cultural cooperation/, 3/ Хүний эрх ба өөрөө засан тохинох эрх /Human rights and Self-Determination/, 4/ Хараат ард түмний асуудал /Problems of Dependent peoples/, 5/

Дэлхий дахины энх тайван, хамтын ажиллагааг хангах /Promotion of World Peace and Cooperation/ зэрэг таван асуудлыг оруулах нь зүйтэй гэж үзэв. Үүнд: Хүний эрх ба өөрөө засан тохинох эрхийн дэд хороо голчлон Палестины асуудал ба арьс өнгөөр ялгаварлан гадуурхах асуудлыг, Хараат ард түмний асуудлын дэд хороо Тунис, Алжир, Мароккогийн асуудлыг хэлэлцэхээр тогтжээ.⁷

4 дүгээр сарын 18-ны өдрийн бүгд хуралдаанд Энэтхэг, Камбож, Цейлон, Египет, Алтан эрэг, Иран, Ирак зэрэг 23 орны төлөөлөгчдийн Тэргүүн үг хэлжээ. Энэтхэгийн Ерөнхий сайд Жавахарлал Неру хэлсэн үгэндээ: “Олон зуун жилийн туршид Ази, Африкийн орнууд олон улсын улс төр, эдийн засаг бусад харилцаанд хэн ч бус “тодорхой субъект” болж оролцож чадахгүй явж иржээ. Тэдний хувь заяаг өмнөөс нь бусад субъектууд илэрхийлж байлаа. Ази тив нь Европ тивийн гадаад зах хязгаар байв. Африк ч мөн адил. Бусад тивийн бусад хүмүүс Ази, Африкийн асуудлыг өмнөөс нь шийдэж байлаа. Одоо энэ бүгдийг өөрчлөх цаг болжээ. Ази тивийн ихэнх үндэстнүүд эдүгээ эрх чөлөө, тусгаар тогтнолоо олов. Энэ бол жирийн нэг улс төрийн өөрчлөлтөөс хамаагүй гүн гүнзгий зүйл. Эрх чөлөө болон өөрсдөдөө түшиж найдах, мөн бусадтай хамтран хорших тийм хүсэл тэмүүллийг ухамсарласан гэсэн үг. Ард түмнүүд, улс орнуудын ийм ухамсарласан хүсэл эрмэлзэл нь тэднийг Бандунгт хурал цуглахад хүргэсэн билээ”⁸ гэжээ.

6 Л.Хайсандай. МНР и развивающиеся страны. УБ., 1982. с. 9-10.

7 А.Appadorai. The Bandung Conference. “India Quarterly” Vol. 11, No 3 (July-September 1955) pp. 212-213

8 Ibid., p. 232.

4 дүгээр сарын 19-ний өдрийн бүгд хуралдаанд Эфиоп, Япон, Иордан, Лаос, Ливан, Либери, Ливи, Непал, Пакистан, Филиппин, Суданы төлөөлөгчид үг хэлсэн байна. Непалын төлөөлөгч Энэтхэгийн Ерөнхий сайд Неру, БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Жоу Энълай нарын тунхагласан таван зарчим бол Ази, Африкийн орнуудын хамтран ажиллахын бодит үндэс мөн гээд тэдгээр зарчмыг тус бага хурлаар авч хэлэлцэхийг санал болгосон байна. Пакистаны төлөөлөгч ЗХУ-ын гадаад бодлогын сөрөг талыг шүүмжлээд “олон улсын маргаантай асуудлыг шийдвэрлэхэд дайныг ашиглахыг” буруушаасан байна. Тэрээр энх тайвныг дэмжих улс хоорондын харилцааны 7 зарчмыг дэвшүүлжээ.⁹

4 дүгээр сарын 20-ны өдрийн бүгд хуралдаанд БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Жоу Энълайн хэлсэн үг, ялангуяа Ази, Африкийн орнуудын хооронд хамтын ажиллагаа тогтоох тухай ажил хэргийн саналуудыг төлөөлөгчид талархан угтаж, Индонезийн хэвлэлүүд бага хурлаас нэгдсэн шийдвэр гарах боломж бүрдэж байгааг тэмдэглэж байжээ. Улс төрийн хороо Палестины асуудал, өөрөө засан тохинох эрхийн тухай асуудал, арьс өнгөөр ялгаварлан гадуурхах асуудал ба арьсны онолын тухай асуудал түүнчлэн, баруун Ириан, Алжир, Марокко, Тунисын ард түмний тусгаар тогтнолын тухай асуудлыг хэлэлцсэн байна.

4 дүгээр сарын 24-ний өдөр

Бандунгийн бага хурлын төгсгөлийн бүгд хуралдаан болж, Бага хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Руслан Абдулгани бага хурлын хамтарсан албан мэдээг уншиж танилцуулжээ. Албан мэдээг баталсны дараа Бирмийн Ерөнхий сайд У Ну, БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Жоу Энълай, Энэтхэгийн Ерөнхий сайд Ж.Неру, Египетийн Ерөнхий сайд Г.Абдель Насер, Пакистаны Ерөнхий сайд Мохаммед Али, БНАВУ-ын Ерөнхий сайдын орлогч Фам Ван Донг, Иран, Ирак, Филиппин зэрэг орны төлөөлөгчид үг хэлсэн байна. Бирмийн Ерөнхий сайд У Ну тус бага хурал бол улс төрийн янз бүрийн систем бүхий орнууд энх тайвнаар зэрэгцэн оршихын тодорхой жишээ боллоо гэв. Жоу Энълай хэлсэн үгэндээ “Тус бага хуралд оролцсон орнууд олон асуудлыг янз янзаар үзэж эдгээр асуудлын талаар янз бүрийн үзэл баримталж байгааг энэ бага хурал үзүүллээ. Тэрчлэн бид санал зөрөлдөөн бүхий асуудлыг зарим талаар авч хэлэлцлээ. Гэвч ийнхүү янз бүрийн саналтай байгаа нь бидний нийтээр хэлэлцэн тохироход саад болсонгүй. Ази, Африкийн орнуудын ард түмэн нь нэг хувь заяатай, нэг хүсэлтэй байгаагийн ачаар бид колонит ёсыг эсэргүүцэн нийтийн энх тайвныг хамгаалж, улс төр, эдийн засаг, соёлын талаар хамтран ажиллахад ийнхүү амжилт оллоо” хэмээн онцлон тэмдэглэсэн байна.¹⁰

“Үнэн” сонин 1955 оны 5 дугаар сарын 4-ний дугаартаа Ази, Африкийн орнуудын бага хурлын төгсгөлийн албан мэдээг бүрэн эхээр нь нийтэлсэн

9 “Үнэн” сонин, 1955.04.22.

10 “Үнэн” сонин, 1955.04.27.

байна. Энэтхэгийн судлаач Аппадорай Бандунгийн бага хурлын төгсгөлийн баримт бичгийн тухайд “Хэдий Ази, Африкийн эдийн засаг, соёлын хамтын ажиллагааны шийдвэрүүд чухал боловч бүх дэлхий Бага хурлын улс төрийн шийдвэрийг сэтгэл догдлон хүлээж байсан. Дэлхийн хүн амын талаас илүү хувийн ёс суртахууны эрч хүч энх тайвныг урагшуулахад хичнээн ач холбогдолтой нь ойлгомжтой байлаа. Бага хурал тэдний хүлээлтийг хөсөрдүүлээгүй юм” гэжээ. Бага хурал колоничлолын бүхий л хэлбэрийг эсэргүүцэж, Тунис, Марокко, Алжирын ард түмний өөрөө засан тохинох эрхийг дэмжиж, Палестины араб ард түмний эрхийг тууштай дэмжиж, НҮБ-ыг илүү хүртээмжтэй болгох, түүнд Камбож, Цейлон, Япон, Иордан, Лаос, Ливи, Непал, нэгдсэн Вьетнам зэрэг улсыг элсүүлэхийг уриалсан байна.

1955 онд Бандунгад хуралдсан Ази-Африкийн 29 орны бага хурал энх тайвнаар зэрэгцэн орших Панча Шилагийн 5 зарчмыг улам бүр цааш баяжуулан өргөтгөжээ. Тус бага хурлаас “Бүх нийтийн энх тайван, хамтын ажиллагааг дэмжих тухай” гаргасан тунхаглалд: хүний эрх ба НҮБ-ын дүрмийн зарчмыг хүндэтгэх, бүх орны бүрэн эрх ба газар нутгийн бүрэн бүтэн байдлыг хүндэтгэх, бүх ястан үндэстний тэгш эрхийг хүлээн зөвшөөрөх, бусад оронд түрэн орох ба дотоод хэрэгт оролцохоос татгалзах, НҮБ-ын дүрмийн дагуу орон бүрийн дангаар буюу хамтаар батлан хамгаалах эрхийг хүндэтгэх, хамтаар батлан хамгаалах тухай

хэлэлцээрийг их гүрний тухайлсан сонирхолд ашиглах ба бусад оронд дарамт үзүүлэхээс татгалзах, аливаа орны нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал болон улс төрийн тусгаар тогтнолын эсрэг түрэмгийлэх буюу хүч хэрэглэхээс татгалзах, олон улсын бүхий л асуудлыг эвийн аргаар зохицуулах, бие биесийн сонирхол ба хамтын ажиллагаанд дөхмийг үзүүлэх, шударга ёс ба олон улсын үүргийг хүндэтгэх эдгээр 10 зарчмын үндсэн дээр улс хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэхийг уриалсан байна.¹¹

3. Бандунгийн бага хурлын талаарх БНМАУ-ын байр суурь

1955 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр Бандунг хотод нээгдэж буй Ази, Африкийн орнуудын бага хурлын Тэргүүлэгчдэд хандан баяр хүргэсэн цахилгааныг БНМАУ-ын Их хурлын Тэргүүлэгчдийн дарга Ж.Самбуугийн нэрийн өмнөөс илгээжээ. Уг цахилгаанд: “БНМАУ-ын Их Хурлын Тэргүүлэгчид энх тайвныг эрхэмлэгч Монголын ард түмний өмнөөс Ази, Африкийн орнуудын бага хуралд оролцогчдод халуун баяр хүргэж байна. Ази, Африкийн орнуудын бага хурал бол олон улсын хоорондын харилцааны хүнд байдлыг сулруулах, бүх нийтийн энх тайван, улс түмний хоорондын аюулгүй байдлыг бэхжүүлэх, Ази, Африкийн бүх ард түмний эрх чөлөө, үндсэний тусгаар тогтнолыг хамгаалах хэрэгт тус дөхөм болох нь дамжиггүй гэдэгт Монголын ард түмэн гүнээ итгэж байна. Ази,

11 A.Appadorai. The Bandung Conference. “India Quarterly” Vol. 11, No 3 (July-September 1955) pp. 213-214.

Африкийн орнуудын бага хуралд оролцогчдод улс түмний хоорондын энх тайвныг бэхжүүлэх хэрэгт ажлын амжилтыг хүсье” гэжээ.¹² Бандунгийн бага хурлыг бүрэн дүүрэн дэмжих нь ЗХУ тэргүүтэй социалист орнуудын нэгдсэн байр суурь байлаа. Хэдийгээр бага хуралд зөвхөн БНХАУ, БНАВУ албан ёсоор оролцсон боловч ЗХУ дэлхийн тавцан дээр Ази, Африкийн орнууд шинээр эрх чөлөө, тусгаар тогтнолоо олж, түрэн гарч ирж байгааг соргоогоор мэдэрч, тэдний эрч хүчийг империалист орнуудын эсрэг глобал өрсөлдөөнд ашиглах, талдаа татахыг хичээж байлаа.

Бандунгийн бага хурал Ази, Африкийн нөлөө бүхий орнууд империализмын эсрэг тавцан дээр нэгдэхэд чухал үүрэг гүйцэтгэв гэж ЗХУ тэр үед үзэж байв. Хэдий империалист чиг баримжаатай зарим орнууд Бандунгийн бага хурлын хэлэлцэх асуудалд Зөвлөлтийн эсрэг шийдвэрийг нялзаахыг оролдсон боловч бага хурал шинэ колониализмыг жигшин буруушааж, олон улсын харилцааны шинж чанарыг илтгэсэн 10 зүйлтэй Бандунгийн зарчмуудыг баталж чадлаа гэж ЗХУ үнэлж байсан байна.¹³

Бандунгийн бага хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Руслан Абдулгани БНМАУ-ын Их хурлын Тэргүүлэгчдэд хандан хариу

ирүүлснийг “Үнэн” сонин нийтэлжээ. Тус хариунд “Ази, Африкийн орнуудын бага хуралд сайн сайхныг хүссэн явдалд талархлаа илэрхийлье. Таны цахилгаан утсанд дурдсан асуудлын талаар тус бага хурлын төгсгөлийн албан мэдээнд тэмдэглэж санал нэгтэй шийдвэр гаргасныг Танд мэдэгдье” гэжээ.¹⁴

“Үнэн” сонин 1955 оны 4 дүгээр сарын 29-ний дугаартаа “Энх тайван, ардчилал, социализмын хүч ялагдашгүй” нэртэй тэргүүн өгүүллийг нийтлэв. Тус өгүүлэлд Бандунгийн бага хурын үр дүнгийн тухай “Ази тив, Номхон далайн сав газарт колонийн мөлжлөгийн бараг 3-ны 1 хувь нь нэгмөсөн устжээ. Ази, Африкийн ард түмэн тус тусын орны гадаад бодлогын чухал асуудлуудыг шийдвэрлэх явдлыг гартаа авч, империалистуудын эсрэг шийдвэртэй тэмцэж байна. Энэтхэгийн нийслэл Дели хотод болсон Азийн орнуудын бага хурал, 1600 сая хүн амыг төлөөлж Бандунг-д болсон Ази, Африкийн орнуудын бага хурал энх тайвны үйл хэрэгт чухал хувь нэмэр болов. Тус бага хурлаас нэгэн дуугаар баталсан хамтын албан мэдээ нь колоничлолын эсрэг тэмцэж, бүх нийтийн энх тайвныг хамгаалан, найрамдал хамтын ажиллагааг бэхжүүлэх гэсэн Ази, Африкийн ард түмний нийтийн эрмэлзлэлийг илэрхийлж байна” гэжээ.¹⁵

12 “Үнэн” сонин, 1955.04.20.

13 Международные отношения на Дальнем Востоке в послевоенные годы. 1945-1957. Том I /1945-1957/. М., 1978, с. 208-209.

14 “Үнэн” сонин, 1955.05.01.

15 “Үнэн” сонин, 1955.04.29.

Хоёр. Бандунгийн бага хурлыг санаачлагч Энэтхэг, Бирм, Индонезтэй дипломат харилцаа тогтоосон нь

БНМАУ Панча-Шила ба Бандунгийн 10 зарчмын үндсэн дээр Азийн томоохон гүрэн Бүгд Найрамдах Энэтхэг Улстай хамгийн түрүүнд дипломат харилцаа тогтоолоо. Дипломат харилцаа тогтоох тухай хэлэлцээг 1955 онд эхлүүлж, 1955 оны 12 дугаар сарын 24-нд дипломат харилцаа тогтоож, Элчин сайд нарыг солилцох тухай Монгол-Энэтхэгийн албан мэдээ нийтлэгдэв. Энэ нь оюун санааны олон зуун жилийн хэлхээ холбоотой Азийн хоёр орон энхийг эрхэмлэн тусгаар тогтнолоо бэхжүүлэх нийтлэг эрмэлзэлтэй явж ирсний үр дүн байлаа. БНМАУ-ын анхны Элчин сайд Б.Очирбат 1956 онд Энэтхэг Улсын Ерөнхийлөгч Р.Прасадад итгэмжлэх жуух бичгээ барив. Энэтхэг Улсын анхны Элчин сайд Р.Кумар Неру мөн онд итгэмжлэх жуух бичгээ барьжээ.

Энэтхэг улсын зүгээс НҮБ болон олон улсын бусад байгууллагад Монгол улсын хууль ёсны байр сууриа олох гэсэн хүчин чармайлтыг ямагт дэмжиж иржээ. БНМАУ-ын Ерөнхий сайд Ю.Цэдэнбалаас Монгол-Энэтхэгийн хооронд дипломат харилцаа тогтоосонтой холбогдуулан БНЭУ-ын Ерөнхий сайд Жавахарлал Неруд явуулсан илгээлтдээ: “НҮБ-ын гишүүн байх Монгол улсын эрхийг идэвхтэй дэмжиж ариун сайхан чармайлт гаргаж байгааг монголын ард түмэн, түүний засгийн газар өндөр үнэлж байна. Эхлээд Энэтхэг, БНХАУ, дараа нь Бандунгийн бага хурлаас

тунхагласан таван зарчим “Панча-Шилаг” БНМАУ-ын засгийн газар бүрэн дүүрэн дэмжиж байгаа бөгөөд тэдгээр зарчим нь улс гүрнүүдийн хамтын ажиллагааны үндэс болох ёстой гэж үзэж байна” гэжээ.¹⁶

Монгол ба Бирмийн ард түмний хооронд нийтлэг ашиг сонирхолд үндэслэн 1956 оны 9 дүгээр сард БНМАУ ба Бирмийн Холбооны хооронд дипломат харилцаа тогтоов. Тухайн үед 677 мянган хав.дөр. км нутагтай, 20 шахам сая хүнтэй Бирмийн Холбооны улс нь Ази, Африкийн орнуудын Бандунгийн бага хурлыг санаачлагчдын нэг байлаа. СнЗ-ийн дарга Ю.Цэдэнбал, Бирмийн Холбооны Улсын Ерөнхий сайд У Ба Све нар хоёр орны хооронд дипломат харилцаа тогтоосныг тохиолдуулан баяр хүргэсэн цахилгаан солилцжээ. Ю.Цэдэнбал цахилгаандаа “Дэлхий дахины болоод Азийн энх тайвны хэрэгт өөрийнхөө хувь нэмрийг оруулж байгаа Бирмийн Холбооны улстай дипломат харилцаа тогтоосон явдалд монголын ард түмэн маш баяртай байна” гэсэн бол У Ба Све “БХУ ба БНМАУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосон явдлыг тохиолдуулан элэгсгээр баяр хүргэсэн явдалд Танд талархлаа илэрхийлье” гэжээ.¹⁷

БН Индонез Улсын Ерөнхийлөгч Сукарно ЗХУ, Югослав, Австри, Чехословак улсад албан ёсоор айлчлаад Бээжин очих замдаа Улсын Их хурлын тэргүүлэгчдийн дарга Ж.Самбуугийн

16 Б. Лхамсүрэн. Монголын гадаад орчин. Төрийн тусгаар тогтнол. УБ., 1995. 100-р тал.

17 “Үнэн” сонин, 1956.11.01.

урилгаар БНМАУ-д нэг хоног зочилсон байна. БН Индонез Улсын Ерөнхийлөгч Ахмед Сукарно Улаанбаатар хотод 1956 оны 9 дүгээр сарын 29-нд хүрэлцэн иржээ. БНМАУ-ын Их хурлын Тэргүүлэгчдийн дарга Ж.Самбуу, Их хурлын дарга Ц.Дүгэрсүрэн, ГЯЯ-ны сайд Д.Адилбиш бусад албаны хүмүүс нисэх онгоцны буудалд угтан авчээ. Ж.Самбуу угтах ёслолын үеэр хэлсэн үгэндээ “БН Индонез Улсын төрийн гарамгай зүтгэлтэн, Ерөнхийлөгч доктор Сукарно манай оронд ирсэн явдал бол Монгол-Индонезийн харилцааг тогтоон хөгжүүлэхэд чухал зүйл бөгөөд Дорно зүгт ба даян дэлхийд энх тайвныг бэхжүүлэх тэмцэлд Монгол-Индонезийн найрамдал, хамтын ажиллагааг цаашид өрнүүлэхэд асар их тус болно. ..Бүх улс гүрэн, ард түмний энх тайвнаар зэрэгцэн орших алдарт таван зарчмыг тунхагласан Бандунгийн түүхт бага хурлыг хуралдуулах хэрэгт Индонез улс ба ноён Ерөнхийлөгч Таны байгуулсан гавьяа зүтгэлийг БНМАУ өндөр үнэлж байдаг юм. БНМАУ нь өөрийн гадаад бодлогод тэр таван зарчмыг тууштай баримталж, даян дэлхийн энх тайвны хэргийн төлөө түүнийг хэрэг дээр биелүүлэхийн тулд цуцалтгүй тэмцэж байна” гэжээ. А.Сукарно хэлсэн үгэндээ “350 гаруй жил империализмын дарлагдалд байгаад 11 жилийн өмнө өөрийн тусгаар тогтнолыг олсон Индонезийн 82 сая ард түмнийг төлөөлж би танай оронд ирлээ. ..Би хүүхэд байхдаа, 40 жилийн өмнө танай орон, танай ард түмэн, танай нийслэл хотын тухай нэгэн ном уншсан билээ.

Та нар урагш их давшилт хийжээ. Бид танайхыг Нэгдсэн Үндэстний Байгууллагад орох асуудлыг дэмжиж байгаа юм” гэсэн байна.¹⁸

БН Индонези Улсын Ерөнхийлөгч Сукарно Монголд албан ёсоор айлчилсны дараа 1957 оны 1 дүгээр сард Монгол-Индонезийн хооронд дипломат харилцаа тогтоож, Элчин сайд зэрэгтэй дипломат төлөөлөгчөө харилцан солилцохоор шийдвэрлэжээ. “Үнэн” сонин 1956 оны 12 дугаар сарын 22-ны дугаартаа энэхүү албан мэдээг нийтэлж, “Монгол-Индонезийн ард түмний найрамдал бэхжитүгэй” нэртэй тэргүүн өгүүллийг хэвлэв. Тус өгүүлэлд “Хятад, Энэтхэг, Индонез зэрэг Ази, Африкийн орнуудын чармайлтаар хуралдсан Бандунгийн бага хурлаас тунхагласан алдарт таван зарчим: бие биеийнхээ бүрэн эрхийг ба нутаг дэвсгэрийн бүрэн бүтнийг хүндэтгэх, үл довтолцох, дотоод хэрэгт үл оролцох тэгш эрхтэй харилцан ашигтай байх, энх тайвнаар зэрэгцэн орших явдлыг талархан дэмжигч улс орнуудын тоо дэлхийн өнцөг бүрт улам нэмэгдсээр байна” гэжээ.¹⁹

1957 онд Энэтхэгийн дэд Ерөнхийлөгч Радхакришнан БНМАУ-д айлчилж ирсэн нь хоёр орны харилцааны түвшинг өндөрсгөв. Улмаар 1959 онд Сайд нарын Зөвлөлийн дарга Ю.Цэдэнбал БНЭУ-д албан ёсны айлчлал хийж Энэтхэгийн удирдагч Жавахарлал Нерутэй яриа хэлэлцээ хийсэн нь Азийн хоёр орны харилцаа улам гүнзгийрэх сайхан үүдийг нээж өгчээ.

18 “Үнэн” сонин, 1956.09.30.

19 “Үнэн” сонин, 1956.12.22.

Гурав. БНМАУ 1955-1957 онд НҮБ-д элсэх үйл ажиллагаагаа эрчимжүүлсэн нь

Дэлхийн 4 гүрний Засгийн газрын тэргүүн нарын Женевийн зөвлөгөөн 1955 онд болсны дараа олон улсын хурцадмал байдал намжих төлөвийг олж, дэлхийн олон орны зүгээс НҮБ-ын бүрэлдэхүүнийг өргөтгөх, гишүүн элсүүлэхэд их гүрнүүд талцан алагчлан ялгаварлаж үзэхийг зогсоох, тус байгууллагын нэр хүндийг сэргээх шаардлага хүчтэй болов. Ази, Африкийн улсуудын Бандунгийн бага хурлаас НҮБ-ын гишүүнчлэлийг өргөтгөхийг шаардаж тодорхой улсуудыг нэр заасан Зөвлөмжийг хүртэл гаргаж байлаа. 1950-иад оны дундаас БНМАУ-ыг НҮБ-д элсүүлэх нь Зөвлөлт-Америкийн төдийгүй, АНУ-Тайваний харилцааны эмзэг хөндүүр асуудал болон тавигдах болсны түүхч Р.Болд номондоо бичжээ. АНУ, ЗХУ, Британи, Францын ГЯЯ-ны сайд нар Женевт 1955 оны 11 дүгээр сард НҮБ-ын гишүүнчлэлийн асуудлаар уулзав. ЗХУ, Канад хоёр БНМАУ-ыг оролцуулан социалист 5 улсыг багтаасан 18 орныг НҮБ-ын гишүүнээр багцаар нь элсүүлэх саналыг 1955 онд дэвшүүлээд байв.²⁰

АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ф.Даллес ЗХУ-ын ГЯЯ-ны сайд В.Молотовтай уулзаж, БНМАУ-ын гишүүнчлэлийн асуудлаар 1955 оны 11 дүгээр сарын 13-нд дэлгэрэнгүй ярилцжээ. Даллес БНМАУ-ыг 18 орны багцаас хасахыг хүссэн байна. Молотов

БНМАУ-ын гишүүнчлэлийг үгүйсгэж болохгүй, Энэтхэг саяхан Монголыг хүлээн зөвшөөрсөн гэж ярьсан байна. Даллес Бандунгийн зөвлөмжид Монголын нэр ороогүй байна гэж маргасан байна. Дөрвөн гүрний Гадаад хэргийн сайд нарын уулзалт үр дүнгүй дуусчээ. Тайвань БНМАУ-ын гишүүнчлэлийн эсрэг хориг тавихаа мэдэгдэж АНУ-аас дэмжлэг хүссэн байв. АНУ-ын хувьд тэдгээр 18 орны дотор багтаж байсан социалист бус “чөлөөт” хэмээх 13 орныг элсүүлэх нь Өрнөдийн нэгдмэл эрх ашгийн хувьд чухал байв.

Иймд АНУ-ын Ерөнхийлөгч Д.Эйзенхауэр Чан Кайши-д хандан БНМАУ-ыг НҮБ-ын гишүүнээр элсэхэд хориг тавих эрхээ хэрэглэхгүй байхыг хүссэн захидлыг 1955 оны 11 дүгээр сарын 22-нд илгээжээ. Эйзенхауэр захидалдаа “Зөвлөлтийн дагуул 5 улсыг оролцуулан 18 орныг гишүүнээр элсүүлэх санал гарсныг та мэдэж байгаа. Эдгээрийн дотор Ар Монгол байгаа юм.” Иймд тэрээр Чан Кайши-д хандан хориг тавихгүй байхыг, ялангуяа чөлөөт 13 улс элсэх төлөвтэй байх аваас хориг тавихгүй түдгэлзэх замаар асуудлыг шийдвэрлэхийг зөвлөж байжээ.²¹ 1955 онд багцаар хэлэлцэгдэж байсан 18 орны дотор Япон мөн багтаж байв. Японы Засгийн газар АНУ, Тайваньд хандан Чан Кайши-д нөлөөлөх,

20 Р.Болд. Монголын тусгаар тогтнол ба АНУ. /1910-1973/. УБ., 2008. 264-265-р тал.

21 Foreign Relations of the United States. 1955-1957. Vol. XI. p. 388.

Гоминьданы Хятадыг БНМАУ-ын асуудал дээр хориг тавих эрхээ түдгэлзэхийг нэг бус удаа янз бүрийн шугамаар тавьж байв.

1955 оны 12 дугаар сард Ерөнхий Ассамблейн гишүүдийн 52 нь 18 улсыг багцаар нь НҮБ-д элсүүлэх тухай Швед зэрэг 28 орны саналыг дэмжиж байв. Гэтэл уул Зөвлөмжийг Аюулгүйн Зөвлөлөөр хэлэлцэхэд Чан Кайши-гийн төлөөлөгч БНМАУ-ын эсрэг хориг тавьсан тул ЗХУ-ын төлөөлөгч Япон, Испани хоёрыг НҮБ-д авах зөвлөмж өгөхөөс татгалзаж улмаар 18 улсыг зэрэг элсүүлэх асуудал нурсан байна. Аюулгүйн Зөвлөлийн 12 дугаар сарын 15-ны онцгой хуралдаан дээр ЗХУ-ын төлөөлөгч БНМАУ, Япон хоёроос бусад 16 улсыг НҮБ-д элсүүлэх шинэ санал тавьсныг Аюулгүйн Зөвлөл, Ерөнхий Ассамблейн дийлэнхи олонхи зөвшөөрснөөр тэдгээр 16 улс НҮБ-ын гишүүн болжээ.²²

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн XI чуулган 1956 онд хуралдах үед БНМАУ-ын Засгийн газар НҮБ-ын гишүүн байх тус улсын эрх зүй ёсны гэж итгэж, Сайд нарын Зөвлөлийн дарга Ю.Цэдэнбалын гарын үсэгтэй өргөдлийг илгээж, өмнөх чуулганы дийлэнхи олонхийн саналыг харгалзан Ерөнхий Ассамблейн ээлжит чуулганаар Монголын өргөдлийг авч хэлэлцэх хүсэлтийг дахин тавьжээ. “Үнэн” сонин 1956 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дугаартаа “Дайны дараах үед БНМАУ нь олон улсын харилцаа, хамтын ажиллагаагаа итгэлтэй өргөжүүлж одоо нилээд олон

оронтой дипломат харилцаа тогтоожээ. Үүний дотор БНХАУ, Энэтхэг, ЗХУ мэтийн их гүрнүүд мөн түүнчлэн Польш, Чехословак, Бирм болон Ази, Европын бусад орнуудыг дурдаж болно. БНМАУ хүн төрөлхтөний ихэнх хувийг /дэлхийн хүн амын хувьд хэлжээ Ц.Б./ хамарсан улсуудтай хэвийн дипломат харилцаатай байна” гэж учирлаж байв.²³

Монголын Засгийн газраас НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Даг Хаммершельдэд илгээсэн бичиг цахилгаануудад тус улсын төлөөлөгчдийг XI чуулганд оролцуулах, НҮБ-ын дэргэд “олон улсын өндөр нэр хүнд бүхий тус байгууллагын үйл ажиллагаатай ойр дотно танилцах, улс хоорондын харилцаагаа улам хөгжүүлэх, монголын ард түмний амьдралын тухай дэлхийн олон нийтэд мэдээлэх боломж олгохын тулд” байнгын ажиглагч суулгахыг хүссэн байна. 1956 онд Аюулгүйн Зөвлөлөөр БНМАУ-ыг гишүүнээр элсүүлэхийн төлөө ЗХУ, Югослав, Иран, Перу саналаа өгч, Чан Кайши ба Батистын Кубын төлөөлөгч татгалзаж, Австрали, Бельги, Англи, АНУ, Франц түдгэлзсэн байна.

1957 онд Монголын Засгийн газраас Аюулгүйн Зөвлөлийн даргын нэр дээр тус орныг НҮБ-д элсүүлэх асуудлыг нааштай шийдвэрлэхийг эрж ГЯЯ-ны сайд С.Аварзэдийн гарын үсэгтэй өргөдлийг өгсөн байна. Энэ удаад БНМАУ-ыг НҮБ-д авах талаар ЗХУ ба Шведийн хамтран оруулсан тогтоолын төслийг АНУ, Филиппин,

22 Монголын дипломатын нэвтэрхий толь бичиг. Дэд боть, УБ., 2014. 484-485-р тал.

23 “Үнэн” сонин, 1956.12.15.

Куба, Колумби, Чан Кайши-гийн төлөөлөгчид татгалзаж, Англи, Франц, Ирак, Австрали түдгэлзсэн байна.²⁴

Хүйтэн дайны уур амьсгал, их гүрнүүдийн зөрчил тэмцэл, үзэл суртлын тэмцлээс болж НҮБ-ын гишүүнчлэлийн асуудал мухардалд орсон байдал Монголыг НҮБ-д элсэхийг олон жилээр хойш татсан бодит шалтгаан байв. Түүнчлэн

БНМАУ гадаад харилцааны туршлага нимгэн, Бандунгийн шийдвэрт өөрийгөө тусгуулж чадаагүй, АНУ Чан Кайши-гийн Тайваньтай холбоотон байсан, БНМАУ олон улсын зарчмын асуудлаар ЗХУ-ыг аялдан дагалдаж, Зөвлөлтийн нөлөөний “тоглоомын улс” гэсэн ойлголт төрүүлсэн байсныг мөн тэмдэглэх нь зүйтэй.

Дүгнэлт

1955 оны 4 дүгээр сард Индонезийн Бандунг хотод хуралдсан Ази, Африкийн 29 орны бага хурал дэлхийн болон бүс нутгийн бодлогод онцгой нөлөө бүхий сонин содон үйл явдал болсон билээ. Нийгмийн өөр өөр байгуулалтай Энэтхэг, Индонез, Бирм, коммунист БНХАУ, капиталист Япон, шинээр тусгаар тогтнолоо олсон Египет, Иран, Ирак зэрэг 29 орны Төрийн тэргүүн, Гадаад хэргийн сайд нар дэлхийн II дайнаас хойш анх удаа хуран цугларч, колоничлолын эсрэг, энх тайвны төлөө өөр хоорондоо ямар зарчмаар хамтран ажиллах, улс төр, эдийн засаг, соёлын тусгаар тогтнолоо хэрхэн бэхжүүлэх, Их гүрнүүдтэй хэрхэн харилцах зэрэг амин чухал асуудлаар хэлэлцэж, Бандунгийн 10 зарчмыг тунхагласан Төгсгөлийн баримт бичгийг гаргаж чадсан билээ. Судлаачид Бандунгийн бага хурлын ач холбогдлыг гуравдагч ертөнцийн орнуудын дуу хоолойг дэлхийн бодлогод хүргэж, олон

улсын харилцааг шударга үндсэн дээр хөгжүүлэх, олон улсын эрх зүйд хөгжиж буй орнуудын эрх ашгийг хамгаалсан томъёолууд оруулж, эвсэлд үл нэгдэх бүхэл бүтэн хөдөлгөөнийг үүсгэн байгуулахад чухал хувь нэмэр оруулсан гэж үздэг. Судлаач А.Ачарья Бандунгийн бага хурлаас хүний эрх ба үндэстний өөртөө засан тохинох эрх, улс орны дотоод хэрэгт үл оролцох зарчим, колониализмын эсрэг байр суурь, бүх нийтийн хамтын аюулгүй байдал зэрэг олон улсын эрх зүйн олон ойлголтыг баяжуулж, дэлхийн II дайны дараах глобал аюулгүй байдлын тогтолцоонд хувь нэмрээ оруулсан гэж үнэлжээ.²⁵

1950-иад оны эхний хагаст ЗХУ болон социалист бусад орнууд капиталист, социалист хоёр систем энх тайвнаар зэрэгцэн орших, Солонгосын хойг, Энэтхэг-Хятадын хойгт эвлэрлийн үйл явцыг дэмжиж, “Женевийн уур амьсгал” дэлхийн бусад хэсэгт нэвтэрч, ялангуяа гуравдагч

24 Монголын дипломатын нэвтэрхий толь бичиг. Дэд боть, УБ., 2014. 485-486-р тал.

25 Amitav Acharya. Who are the norm makers? The Asian-African Conference in Bandung and the Evolution of Norms. “Global Governance”, Vol. 20, No 3 (July-Sept. 2014), pp. 410-412.

ертөнц буюу шинээр бүрэн эрхээ олсон Ази, Африкийн тэргүүлэх орнууд империализмын эсрэг, колоничлолын эсрэг үндсэн дээр “эвсэлд үл нэгдэх” бодлого баримтлах болсныг бүрэн дүүрэн дэмжих болов. Хоёр систем зэрэгцэн орших зарчмын дагуу улс хоорондын харилцааны хурцадмал байдал, “хүйтэн дайныг” сааруулах алхмууд хийгдсэн үеийг Хрущевын “дулаарлын үе” хэмээн түүхэнд үздэг. ЗХУ өмнө нь “капитализмыг аялдан дагалдагч” хэмээн үзэж байсан Энэтхэг, Индонез, Бирм зэрэг орнуудад хандах хандлагаа эрс өөрчилж, тэднийг эвсэлд нэгдүүлэхгүй байх, хоёр эсрэг тэсрэг системээс гадуур орших “энх тайвны бүс” хэмээн үзэж өөртөө татахыг чармайж байв.²⁶ Ийм нөхцөлд БНМАУ хэдийгээр тус бага хуралд уригдаагүй албан ёсоор оролцоогүй боловч, Азийн социалист орны хувьд тус бага хурлын үр дүнг бүрэн дүүрэн сайшааж, ялангуяа Бандунгийн 10 зарчмын үндсэн дээр Ази, Африкийн нийгмийн өөр байгуулалттай орнуудтай харилцаа тогтоох, тэдний дэмжлэгийг олж авахад онцгой анхаарсан байна.

Бандунгийн бага хурлыг санаачлагч Энэтхэг, Индонези, Бирм болон Ази, Африкийн бусад орнуудтай 1950-иад оны хоёрдугаар хагас, 60-аад оны эхээр дипломат харилцаа тогтоосон явдал БНМАУ-ын гадаад харилцаанд

Ази, Африк руу чиглэсэн шинэ цонхыг нээж, гадаад харилцаандаа социалист бус орнуудтай өргөн харилцаа тогтоох шинэ үе шатыг нээж чадсан юм. Хоёрт, олон улсын хамтын нийгэмлэгт нэгдэх явдалд Энэтхэг, Индонез, Бирм зэрэг Азийн томоохон орнуудын дэмжлэгийг олж авсан явдал 1961 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагад элсэхэд маш чухал хүчин зүйл болсон нь дамжиггүй. Гуравт, тэдгээр орнууд хожим нэгдэн орсон Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөний зорилго, үйл ажиллагааны зарчмыг ч БНМАУ талархан хүлээн авчээ. 1961 онд Белградад болсон ЭҮНХ-ий зохион байгуулах хурлын талаар нам, төрийн төв хэвлэлд мэдээлж, түүнээс гарсан тунхаглалын үзэл санааг дэмжиж байсан байна. Өргөн утгаар, Бандунгийн бага хурал, түүнийг санаачлагч Ази, Африкийн нөлөө бүхий орнуудтай дипломат харилцаа тогтоосноор дэлхийн тавцан дахь БНМАУ-ын байр суурь бэхжиж, НҮБ-д өөрийн хууль ёсны байр сууриа олж эзлэх, социалист системээс гадна дэлхийн бодлогод улам бүр нөлөө үзүүлэх болсон хөгжиж буй орнуудтай харилцаа тогтоох, цаашилбал 1960-аад оны дундуур Их Британи, Франц зэрэг капиталист орнуудтай харилцаа тогтооход чухал түлхэц болж өгчээ.

26 Н.Верг. История Советского государства, “Прогресс-Академия”, М., 1995. с. 386-391.

Ашигласан материал

- Д.Баярхүү. Олон улсын харилцаа ХХ зуунд. УБ., 1994.
- Р.Болд. Монголын тусгаар тогтнол ба АНУ. /1910-1973/. УБ., 2008.
- Б.Ширэндэв. Далайн давалгаанаар / Туужчилсан роман/.УБ., 1993.
- Б.Ширэндэв. Түүвэр зохиол. 8-р боть. УБ., 2012
- Б.Лхамсүрэн. Монголын гадаад орчин. Төрийн тусгаар тогтнол. УБ., 1995.
- Л.Хайсандай. МНР и развивающиеся страны. УБ., 1982.
- Монгол Улсын түүх, УБ., 2003. 5-р боть.
- Монголын дипломатын нэвтэрхий толь бичиг. Дэд боть, УБ., 2014.
- Международные отношения на Дальнем Востоке в послевоенные годы. 1945-1957. Том I /1945-1957/. М., 1978.
- A.Appadorai. The Bandung Conference. "India Quarterly" Vol. 11, No 3 (July-September 1955)
- Foreign Relations of the United States. 1955-1957.Vol. XI.
- "Үнэн" сонин. 1955.04.20, 1955.04.22, 1955.04.27, 1955.04.29, 1955.05.01, 1956.11.01, 1956.09.30, 1956.12.22, 1956.12.15.

The Bandung conference and the MPR opens new window towards Afro-Asian countries (1955-1961)

Batbayar Tsedendamba

*Ambassador Extraordinary and Plenipotentiary, Sc.D
Institute History and Ethnology, Mongolian Academy of Sciences,
Ulaanbaatar, Mongolia
E-mail: tsedendamba.bud@gmail.com*

Abstract: *Afro-Asian countries liberated from colonialism by the end of the WWII became a new factor in international relations. Most of them sought to establish a peaceful co-existence with other countries. Pancha-Shila five principles have been first proclaimed by India and China in 1954. These five principles proclaimed respect for sovereignty and territorial integrity, mutual non-aggression, equal and mutual usefulness, peaceful coexistence. The Bandung Conference of 29 Asian and African countries held in Indonesia in April 1955 was a significant event in international relations. It proclaimed famous 10 Bandung principles which were embraced by the Mongolian People's Republic enthusiastically.*

Keywords: *The Bandung conference, Asian and African countries, 5 and 10 principles of peaceful coexistence, the peaceful policy of the Mongolian People's Republic.*

<i>The day of submission:</i>	2020.5.4
<i>Completion of review:</i>	2020.6.7
<i>Final decision for acceptance:</i>	2020.6.20